

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2023 ОНЫ 07 ДУГААР САРД  
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

Сайншанд

/2023.07.03/ Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 40,0 сая төгрөгийн нөхөх олговор авахаар тогтоогдсон Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан Д.Эрдэнэмандаагийн зээ хүү/нэхэмжлэгч/ Д.Бат-Очирт нөхөх олговрын мөнгийг шилжүүлсэн баримтыг гардуулан өгсөн.

/2023.07.04/ Дорноговь аймгийн ИТХ-ын ээлжит 12 дугаар хуралдааныг зохион байгуулж 14 асуудал хэлэлцэн 12 шийдвэрийг батлан гаргасан.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. “Цахим Дорноговь аймаг” зорилтот хөтөлбөр батлах тухай
2. “Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцад хамруулах журам”-ыг шинэчлэн батлах тухай
3. Аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай
4. Аймгийн 2023 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Хөрөнгийн хөдөлгөөний тухай
6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтэд санал авах тухай
7. Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт
8. Аймгийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсох
9. Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай
10. Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Н.Алдарбаярын төлөөлөгчийн албан хуудсаар ирүүлсэн саналыг хэлэлцэх
11. Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Ган-Эрдэнийн төлөөлөгчийн албан хуудсаар ирүүлсэн саналыг хэлэлцэх
12. Аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 01/89 дүгээр албан бичгийн хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээллийг сонсох
13. Маргаан бүхий асуудлыг хуульд заасан үндэслэлээр хянан шийдвэрлүүлэх тухай

14. Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай

/2023.07.27/ Их соён гэгээрүүлэгч Д.Данзанравжаагийн 220 жил, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн хошой одонт” Дорноговь аймгийн түүхт 92 жилийн ойн хүрээнд төрийн дээд одон медаль гардууллаа.

Хүний Гавьяат эмч Цэрэндоржийн Төмөрмөнх,

Хүний Гавьяат эмч Дашнямын Дангаа,

Үйлчилгээний гавьяат ажилтан Намсрайн Чимгээ,

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Лувсанчүлтэмийн Эрдэнэбат Монгол Улсын гавьяат цол тэмдгээр шагнуулсан.

### **Аймгийн ИТХ-ын даргын шагнал**

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр 10 иргэнийг шагнаж урамшуулсан.

### **Аймгийн ИТХ-ын даргын захирамж**

Аймгийн ИТХ-ын даргын нийт 16 захирамж гарснаас ангилбал Зардал гаргах тухай-1, Зардал батлах тухай-3, Шагнах тухай-1, Хүндэтгэл үзүүлэх тухай-3, Дэмжлэг үзүүлэх тухай-4, Буцалтгүй тусламж олгох тухай-2, бусад-2 шийдвэр гарсан байна.

### **Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал**

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын А тушаал 7 гарснаас Хөрөнгө зарцуулах тухай-3, Ажлын хэсэг байгуулах тухай-1, Албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай-1, Бусад-2 тушаал гарсан.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС**  
**2023 ОНЫ 07 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**

**Дотоод ажил:**

Аймгийн Засаг даргын Захирамж А 110, Захирамж Б 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А 6, Тушаал Б 9 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 110 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 191 албан бичиг ирснээс 15 нь хугацаатай албан бичиг ирж хугацаанд шийдвэрлэсэн. Байгууллагаас 84 албан бичиг бусад байгууллага, иргэнд хүргүүлсэн.

**Өргөдөл, гомдол, шагнал:**

7-р сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж нийт 391 өргөдөл, гомдол ирүүлсний 200 нь Засгийн газрын 11-11 төвөөс ирүүлсэн, 191 нь бичгээр болон иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар, <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар ирсэн байна. Эдгээрийн 12 утсаар болон цахимаар ирүүлсэн өргөдөл байна.

07 дугаар 31-ны байдлаар нийт 55 өргөдөл гомдол судлагдах шатандаа болон хугацаа хоцорч байна.

Эдгээрийн 21 нь хуулийн хугацаа буюу 30 хоног хэтэрсэн байна.

Өмнөх сард хүлээн аваад судлагдаж байсан 19 өргөдөлд хариуг өгөв.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 183 санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 97,0 хувь нь санал, хүсэлт, 1,9 хувь нь гомдол, 1,1 хувь нь талархал байна.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 139 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Эдгээр нь:

1. Монгол Улсын гавьяат зүтгэлтэн цолоор -3
2. Хөдөлмөрийн гавьяаны улан тугийн одонгоор -11
3. Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор -4

4. Алтан гадас одонгоор -96
5. Цэргийн гавьяаны одонгоор -1
6. Хөдөлмөрийн хүндэт медиалаар 22
7. Цэргийн хүндэт медиалаар -2 иргэнийг шагнуулахаар уламжилсан байна.

Ардын хувьсгалын 102 жил, Дорноговь аймаг байгуулагдсаны 92 жил, Говийн догшин ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гаргаж хамт олноо тэргүүлэн ажилласан 125 иргэнд төрийн дээд цол, одон, медаль гардуулах үйл ажиллагааг нэгдсэн журмаар зохион байгуулав.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар материал ирүүлсэн 95 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргын “Жуух”-аар 31, “Өргөмжлөл”-өөр 89 иргэнийг шагнав.

#### **Мэдээллийн технологийн чиглэлээр:**

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 103 мэдээг албан ёсны цахим хуудас болон сайтад байршуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

#### **ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:**

- ❖ Хүний эрхийн төлөв байдлын тайланг Засгийн газрын Хүний эрхийн хороонд тайлагнах ажлыг зохион байгуулсан.
- ❖ ЗГ-ын 11-11 төвд ирсэн гомдол, мэдээлэлтэй холбогдуулан боомтын хурал зохион байгуулсан.
- ❖ Сумдын Засаг дарга нарын цахим хуралд авилгийн эсрэг үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим нөлөөллийг ажиллагааг идэвхжүүлэн ажиллах чиглэл өгсөн.
- ❖ Иргэнээс ирсэн гомдлын дагуу Сайншанд сумын захирагчийн албаны үйл ажиллагаанд хууль, эрх зүйн чиглэлээр хяналт, шалгалт хийж илтгэх хуудсыг боловсруулан ТАСЗ-д хүргүүлсэн.
- ❖ Сайншанд сумын Засаг дарга, тамгын даргаас ирүүлсэн захирамж баримт бичгийг хянан үзэж хариу хүргүүлсэн.
- ❖ Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагуудтай хамтран тамхи зарах тусгай

зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах чиглэлийг Сайншанд сумын Засаг дарга, Цагдаагийн газарт хүргүүлсэн. Уг чиглэлийн дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газраас уг гомдолтой холбогдуулан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж зөвшөөрөлгүй цэгт тамхи худалдсан 1 иргэний 294 хайрцаг тамхийг хураан улсын орлого болгож, 2 аж ахуйн нэгж байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

- ❖ Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл- хууль зүйн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах ажлыг зохион байгуулсан.
- ❖ 2023.06.23-ны өдөр “ Хамтын ажмллагаа ба эерэг өөрчлөлт” төслийн уралдааны үр дүнгийн уулзалт зохион байгуулсан.
- ❖ НЭГ ЗАМ – НЭГ СОЁЛ нээлттэй үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдийг замын хөдөлгөөнд оролцохдоо соёлтой оролцохыг уриалсан.
- ❖ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар сургалтад хамрагдаж, сумдын хууль эрх зүйн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, чиглэл хүргүүлсэн.
- ❖ Авилгийн эсрэг нэгдье нөлөөллийн аянд сумдын алба хаагчдыг уриалж богино хэмжээний бичлэгийг цахимд байршуулсан.
- ❖ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэж байгаа нэр бүхий компаниудад гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2023.06.27-ны өдөр мэдэгдэл хүргүүлсэн. Тус мэдэгдэлд хууль тогтоомж болон гэрээнд заасан үүргийн хэрэгжилтийг хангах, ашиглалтын явцад шаардлага хангахгүй болсон эд зүйлийг засварлан сайжруулж ажиллах үүрэг чиглэлийг тусгав.
- ❖ Хамрын хийд “ Юманд хэмжээ бий” арга хэмжээний хүрээнд ажлын хэсэг зохион байгуулж ажиллаж байна.
- ❖ Хил хязгааргүй алхам ТББ-аас явуулсан Газрын ерөнхий хууль, ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцүүлэгт оролцсон. Уг хэлэлцүүлэгт байгаль орчин, газрын албаны мэргэжилтэн зэрэг 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.
- ❖ Түрээсийн орон сууцны журмыг боловсруулсан.

- ❖ Аймгийн нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн зарын хугацааг сунгасан.
- ❖ Аймгийн Засаг даргын Тамгын газраас гаргаж байгаа захирамж, гэрээг хянаж ажилласан.
- ❖ Төрийн албаны зөвлөлөөс хяналт, шалгалт хийсэнтэй холбогдуулан холбогдох судалгаа, тайлан, мэдээг гаргаж ажилласан.
- ❖ Хэлтсийн тайлангаа эцэслэн боловсруулсэн.
- ❖ Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор сум, баг, байгууллагын иргэдэд мэдээлэл хүргэсэн.
- ❖ Цагдаагийн газар, прокурорын газраас ирсэн эхний хагас жилийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллийг хүлээн авч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар богино хэмжээний нөлөөллийн бичлэг хийж цахимд байршуулсан.
- ❖ Хэв, журам аюулгүй байдлын салбар комиссоос баяр наадмын өдрүүдэд замын хөдөлгөөнд соёлтой оролцох, архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхээс татгалзах, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, ахуйн осол гэмтлээс сэргийлэх, нийтийн хэв журмыг сахих, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх /хулгай, дээрэм, залилах, эд хөрөнгө устгах, гэмтээх.../, хурдан морины уяач, бөх, сур, шагайн харваачид холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаа баримтлах хүрээнд - ХҮНДЭТГЭЛ ДҮҮРЭН ХУТАГТЫН НААДАМ нөлөөллийн аян зохион байгуулж, цахим сүлжээнд байршуулсан.
- ❖ Хил хамгаалах ерөнхий газрын даргад мэндчилгээ, гарын бэлгийн хамт явуулсан.
- ❖ ИТХ үл хөдлөх эд хөрөнгийн татварын хэмжээ тогтоох төсөл бэлтгэсэн.
- ❖ ТББ-уудтай 2 удаагийн уулзалт зохион байгуулсан.
- ❖ Боомтын сэргэлтийн салбар хорооноос ирсэн чиглэлийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- ❖ Цахим нөлөөллийн видео бичлэгүүд хийсэн.

- ❖ Мэргэжилтнүүд сур, ёслол хүндэтгэлийн салбар хороодод холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- ❖ Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор сум, баг, байгууллагын иргэдэд мэдээлэл хүргэсэн.
- ❖ Цагдаагийн газар, прокурорын газраас ирсэн эхний хагас жилийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллийг хүлээн авч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар богино хэмжээний нөлөөллийн бичлэг хийж цахимд байршуулсан.
- ❖ Хил хамгаалах ерөнхий газрын даргад мэндчилгээ, гарын бэлгийн хамт явуулсан.
- ❖ ИТХ үл хөдлөх эд хөрөнгийн татварын хэмжээ тогтоох төсөл бэлтгэсэн.
- ❖ ТББ-уудтай – удаагийн уулзалт зохион байгуулсан.
- ❖ Хэв журам, аюулгүй байдлын салбар комиссыг хоёр удаа хуралдуулсан.
- ❖ Боомтын сэргэлтийн салбар хорооноос ирсэн чиглэлийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- ❖ Цахим нөлөөллийн видео бичлэгүүд хийж, түгээсэн.
- ❖ Мэргэжилтнүүд Үндэсний сурын салбар хороо, Төрийн ёслол хүндэтгэлийн салбар хороодод ажилласан.

## **ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС:**

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Эрт илрүүлэх, үзлэг шинжилгээ оношилгоог эрчимжүүлэх” тухай цахим сургалтанд хамрагдсан.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хүчирхийлэлд өртсөн 1 хүүхдийг СЭМҮТ-д нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх асуудлыг шийдвэрлэн, 10 хоног хэвтэн эмчлүүлэхээр болсон.

Цахим орчинд “Жирэмсэн эхчүүдэд хүргэх зөвлөмж” 229 хүнд, “Шүдээ зөв угааж сурцгаая” хүүхдэд зориулсан бусад зөвлөмж 197 хүнд, Наршилт, үер уснаас сээрэмжлүүлэх бусад цаг үеийн холбогдолтой зөвлөмжийг 303 хүнд хүргэсэн.

сум, өрхийн зорилтот бүлгийн 06-60 сар хүртэлх насны хүүхдийг ЭМГ-ын даргын 2017 оны А/65 дугаар тушаалын дагуу Гэр сувилалд хамруулах ажлыг зохион байгуулах зорилгоор өрх сумын ЭМТ-үүдэд албан бичиг хүргүүлсэн

“Гүзээгүй монгол эр хүн аян” -ы хүрээнд Агатова эрүүл мэндийн төвтэй хамтран ШШГГ-ын 17 албан хаагчийн артерийн даралт үзэж, биеийн жингийн индексийг тодорхойлж Эрчүүдийн эрүүл мэнд, Таргалалт өвчин зэрэг сэдвүүдээр сургалт хийж зөвлөгөө өгсөн.

Цахим орчинд Наршилтаас сэргийлэх 6 зөвлөмжийг байршуулж 7601 хандалт авсан байна.

Аймгийн баяр наадам болж буйтай холбоотой ХХДӨ-өөс урьдчилан сэргийлэх, орчноо бохирдолгүй байлгая, Эрүүл наадацгаая, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх газарт тавигдах шаардлага, наршилтаас урьдчилан сэргийлэх зэрэг сэдэвтэй зөвлөмжийг ЭМГ-ын цахим сүлжээнд нийтлэсэн .

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд жирэмсэн эхчүүд, гэр бүлийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын 2023 оны сүүлийн хагас жилийн хуваарийг гарган ЭМГ-ын даргаар батлуулж, НЭ-ийн төрөх тасагтай хамтран 2023 оны 07 сарын 27-нд Төрөлтийн үеийн зөвлөгөө, зөв түлэлтийн тухай сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтанд 12 жирэмсэн эх хамрагдаж, “Хүүхдээ хөхүүлэх анхны алхам”, “Эхийн хөх яагаад зангирдаг вэ”, “Хүүхэд хөхний сүүндээ цадаж байгаа эсэхийг хэрхэн мэдэх вэ” зэрэг гарын авлага хүргүүлэн гарын үсгээр баталгаажуулсан.

ЭМЯ-ны 6/3388 албан бичгийн хүрээнд ЭМГ-аас зохион байгуулсан үйл ажиллагааны хагас жилийн тайланг бичиж 869 албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн.

Нийтийн эрүүл мэндийн газарт “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” аяны тайланг 17 сум, өрхийн эрүүл мэндээс авч нэгтгэн хугацаанд нь хүргүүлэв.

ЭМЯ-ны Нийтийн Эрүүл мэндийн газарт ЭМС-ын А/625 дугаар тушаалын хагас жилийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хүргүүлэв.

13 сумын ЭМТ-ээс ерөнхий гэрээний 3-р улирлын захиалгыг татан авч нэгтгэн, цахим тендерт захиалгын хийж, нийт 55 төрлийн 37.2 сая төгрөгний эм, эмнэлгийн хэрэгсэлд 13 эм ханган нийлүүлэх байгууллага шалгарч, татан авч ЭМБ-уудад хүргүүлэн ажиллаа.

Үндэсний их баяр наадмын үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах тухай Эрүүл мэндийн сайдын 2023 оны 04 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын чиглэл хүргүүлэх тухай 2023 оны 02/898 дугаар албан бичгийн дагуу, хариуцлагатай жижүүрийн хуваарь, ажиллах чиг үүргийг Эрүүл мэндийн газрын 2023 оны А/98 дугаар тушаалаар батлан эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэн ажиллав. Тухайн үед хариуцлагатай жижүүр ЭМБ-аас мэдээг нэгтгэн 14, 19 цагуудад нэгтгэн аймгийн Онцгой комисс, 2023 оны 07 сарын 10-17 хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээний тайланг ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газарт 2023 оны 849 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлэн ажиллалаа.



Магадлан итгэмжлэлийн баг Хатанбулаг, Хөвсгөл, Зүүнбаян сумдын эрүүл мэндийн төвүүд, Бүрдэнэ бөөрний сувилал, Талст зам өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ажиллав

Дэлхийн банкны санхүүжилттэй Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй “ Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд нийлүүлэгдэх “Эмнэлгийн хог хаягдлын ариутгах Автоклав болон дагалдах иж бүрдлийг хүлээн авч, Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/111 дүгээр тушаалаар 13 сумын ЭМТ-үүдэд хүргүүлэн ажиллаа.

Аймгийн Засаг даргын А/455 дугаар захирамжаар батлагдсан 10/21/04 дүгээр хамтарсан удирдамжийн хүрээнд Хамрын хийд орчмын гэр буудал, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 6-иргэн, 1-ААН-ийг хамруулан төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгуулахаар аймгийн ХХАА-н газрын хүнсний чанарын хяналтын улсын байцаагчтай хамтран 44 заалттай албан шаардлага-5, 10 заалттай зөвлөмж-1 тус тус бичсэн.

Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу Үндэсний их баяр наадмын үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулахаар Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дэмжлэгт хяналт хийсэн.

Иргэнээс ирүүлсэн гомдлын мөрөө 10-21/03 дугаартай удирдамжийн хүрээнд Сайншанд сумын 2 дугаар багт байрлах Аймгийн Нэгдсэн эмнэлэгт төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Шалгалтын явцад 3 дутагдал илрүүлж арилгуулахаар улсын байцаагчийн 3 заалт бүхий 1 албан шаардлага хүргүүлсэн. Гомдлыг хуулийн хугацаанд хааж гомдол гаргагчид мэдэгдсэн.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын 2023 онд баталсан “Эмнэлгүүдэд төлөвлөгөөт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Эрдэнэ сумын Бүрдэнэ багт байрлах Дагшин эрдэнэ ОНӨААТҮГ-ийн Бүрдэнэ булаг сувилалын үйл ажиллагаанд эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт хийхэд 54% буюу их эрсдэлтэй үнэлэгдсэн. Илрүүлсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 13 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

Уламжлалт анагаах ухаан рашаан сувилаллын төвд холбогдох хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн.

Баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулах, худалдааны комиссын хуралд сууж хүнсний худалдаа эрхлэгч нарт хяналт шалгалт хийх талаарх санал оруулж, хоол үйлдвэрлэл эрхлэгч нарт эрүүл ахуйн зохистой дадал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийсэн.

Баяр наадмын 3 өдөр хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч 17 аж ахуй нэгж, 109 иргэний үйл ажиллагаанд эрүүл ахуйн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулж илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулж, хяналт тавьж ажиллаа.

Баяр наадмын үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд хяналт тавьж ажиллан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Ус ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлын хэсгийг чадавхижуулах сургалтад хамрагдаж Сайншанд сумын уст цэгүүдийг тандсан.

Цагдаагийн 2 алба хаагчид холбогдох зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж хяналтын прокурорт хүргүүлсэн.

### **БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Боловсролын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан аймгийн хэмжээнд 55 байгууллагын 2024 оны төсвийн төслийг цаг хугацаанд хийж гүйцэтгэн 5 болон 3 жилийн тэтгэмж авах цэцэрлэг сургуулийн 482 багш, ажилтаны 3,673,600.0 /Гурван тэрбум зургаан зуун далан гурван мянга зургаан зуун төгрөг/-ийг улсын төсөвт тусгуулсан.

Боловсролын салбарын 55 байгууллагын 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн БЕГазарт нэгтгүүлэх шатандаа явагдаж байна.

2023 оны 08-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээний нэгтгэл ажил хийгдэж байна.

Сурагч солилцоогоор япон улсруу явах сурагчдын сонсон шалгаруулалтыг хийж сурагчидын нэрсийн жагсаалтыг хүргүүлж ажилласан.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **Хүүхдийн хөгжил оролцоо, эрхийг хамгаалах чиглэлээр:**

-Үндэсний их баяр наадмын хүрээнд энэ оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс 23-ны хооронд нийт 13 сумын баяр наадмын ойн арга хэмжээ зохион байгуулагдан 1307 морь, 495 хүүхэд уралдаанч хүүхдийн цахим бүртгэлд бүртгэгдэн, уралдааны замд уралдсан. Уралдааны замд 7 хүүхэд мориноос унаж, 3 хүүхэд хөнгөн гэмтэл авч, 4 хүүхэд гэмтэл бэртэлгүй, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар сумдын НБМ-дэд 2 удаагийн цахим сургалт, хэлэлцүүлэг, 6 төрлийн зөвлөмж, шторк, 1 удаагийн ТВ мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажилласан.

-“Нэрт соён гэгээрүүлэгч, говийн ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр наадмын арга хэмжээ энэ оны 7 дугаар

сарын 27-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Хурдан морины уралдааны явцад уралдаанч хүүхдийг цахим бүртгэлд хамруулан, холбогдох хууль журмын дагуу тавигдах шаардлагуудыг бүрэн хангуулж, нийт 9 насны 290 морь, 162 хүүхэд уралдаанд оролцсон байна. Уралдааны явцад 2 хүүхэд мориноос унаж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн. Эмнэлгийн дүгнэлтээр бэртэл, гэмтэлгүй хөнгөн гэж оношлогдсон. Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад Баяр наадмын Морины комисс, Цагдаагийн байгууллага, Нэгдсэн эмнэлэг, ХХҮГ-ын холбогдох албан тушаалтнууд хамтран ажиллаж, Монгол Улын Хүний эрхийн Үндэсний комиссоос хяналт тавин, зөвлөн тусалсан.

-Байгууллагын даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг 27 хамтарсан багт 10,200,000 (Арван сая хоёр зуун) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг чанартай хүргэн, үр дүнг тайлагнаж ажиллах зөвлөмжийг хүргэсэн.

Дорноговь аймгийн Цагдаагийн газрын мөрдөгчийн тогтоолоор Хамгаалах байрны аюулгүй хамгаалалтад байгаа насанд хүрээгүй хохирогч У.Э болон насанд хүрсэн хохирогч Н.У, мөн хохирогч А.Н нарыг 7 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Сэтгэц, эрүүл мэндийн Үндэсний төвд үзүүлж сэтгэц, эмгэг судлалын дүгнэлт гаргуулж, хохирогч А.Н-ийг тус төвийн хүүхэд өсвөр үеийн клиникийн төвд хүүхдийн бие, сэтгэл зүйд нөлөөлөх эмийн эмчилгээнд хамруулсан.

Хүүхэд болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой. Холбогдох Хамтарсан багт нь мэдэгдэж кейсүүд дээр Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, Хүүхдийн эрсдлийн үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээ холбогдох кейс менежментийг бүрдүүлэн ажиллаж шийдвэрлэн илтгэх хуудсаар баталгаажуулан ажиллаж байна. Энэ сард Түр хамгаалах байранд Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй 1 хүүхдийг хүлээн авч нөхөн сэргээх хариу үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Түр хамгаалах байранд үйлчлүүлэгчдэд үзүүлсэн нөхөн сэргээх үйлчилгээний 1090293 төгрөгийн зардлын баримтыг үндэслэн зардлын хуваарилалт хийж 2 тушаалын төсөл боловсруулан холбогдох мэргэжилтнүүдээр хянуулж даргаар батлуулан, санхүүчид өглөө. Албан ажлаар Улаанбаатар хот руу 2023.07.30-ны орой явж СЭМҮТ-ийн хүүхэд, өсвөр үеийн клиникийн тасгаас Н охиныг 2023 оны 7 сарын 31-ний өдөр гарган ТХБ-нд авч ирсэн.

-Байгууллагын даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг 27 хамтарсан багт 10,200,000 (Арван сая хоёр зуун) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүүхдийн эрхийн зөрчил, гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг чанартай хүргэж, үр дүнг тайлагнаж ажиллах зөвлөмжийг хүргэсэн.

Жаргалан зуслангийн бэлтгэл ажлын хүрээнд орчны гадна дотно цэвэрлэгээ, засвар үйлчилгээг байгууллагын ажилтнуудын хүчээр хийж, зусланд амрах хүүхдийн бүртгэлийн мэдээллийг орон нутгийн ТВ, цахим сүлжээгээр иргэд, олон нийтэд хүргэсэн. Зуслангийн эхний ээлжинд 59 хүүхэд хамрагдан энэ оны 7 дугаар сарын 31-ний өдөр эхний ээлжийг хүлээн авч, хөгжлийн хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг явуулсан. Аймгийн Засаг даргаас 34,000,000 (Гучин) санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн.

"Нэрт соён гэгээрүүлэгч, говийн ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр наадмын арга хэмжээний өдрүүдэд нийтийн эзэмшлийн талбайд сайн дурын ажилд 1 чиглүүлэгч, 63 өсвөр үе, залуучууд 3 өдөр ажилласан. Нийт сайн дурын ажилд оролцсон өсвөр үе, залуучууддаа батламж гардуулсан.

Мөн албадлагын чанартай арга хэмжээ авсан Б-д "Мэргэжилд хүйс хамаатай юу?" сэдвээр ганцаарчилсан сургалт зохион байгуулсан.

### **Захиргаа, хүний нөөц, архив, албан хөтлөлтийн чиглэлээр**

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ТЗ-ны 6, ТҮ-ний 10 албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчилсэн шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангасан. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд үнэлгээ хийж, нийт 20 албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.

Төрийн байгууллагын цахим шуудан хаягаар ирүүлсэн болон цаасаар ирсэн 14 албан бичгийг бүртгэж холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж бүртгэсэн. Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилох тухай 1 албан бичиг ирүүлснийг газрын даргын цохолтоор Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Отгоннямыг Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилон хариуг хүргүүлсэн.

Явуулсан 9 албан бичгийг бүртгэж холбогдох байгууллагуудад цахимаар болон цаасаар уламжилсан. Үүнээс 5 албан бичгийг эх хувь цаасаар хүргэж, Able программд шивж оруулсан.

### **СОЁЛ УРЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

### **ЗОРИЛТОТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ:**

"Нээлттэй Дорноговь" зорилтот жил, Говийн Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан "Ноён хутагт Данзанравжаа" уран бүтээлийн уралдааныг зохион байгууллаа. "Ноён хутагт Данзанравжаа" уран бүтээлийн уралдаанд 28 уран бүтээлчийн 58 бүтээл ирснээс 23 бүтээлийг дэлгэн үзэсгэлэн гаргасан. Уран бүтээлийн үзэсгэлэнд Дорноговь аймгийн Хатанбулаг

сумын харьяат Урлагийн гавьяат зүтгэлтэн, Ардын зураач Л.Гаваагийн хүү Алтангадас одонт, Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач Г.Төмөр, Монгол Улсын Ардын зураач Ц.Байды зэрэг уран бүтээлчид уран бүтээлээрээ оролцож, нээлтийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн.

“Ноён хутагт Данзанравжаа” уран бүтээлийн уралдааны шүүгчдээр:

- Монголын урчуудын эвлэлийн ерөнхийлөгч - П.Ганбат
- Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач -Н.Орхон
- Монголын урчуудын эвлэлийн гишүүн, Алтангадас одонт зураач -З.Уянга
- Дүрслэх урлагийн академийн уран зургийн тэнхимийн эрхлэгч МУСТА, Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач - Г. Амарсанаа
- Монголын урчуудын эвлэлийн гишүүн, уран барималч - Б. Лхагважав нар ажиллаж, шилдгүүдээ тодрууллаа.

Энэхүү уран бүтээлийн уралдаанд: Уран зураг төрөлд- Гаваагийн Төмөр, Уран баримал төрөлд- Насанбуянгийн Золжаргал,Зураасан зураг төрөлд- Д.Гунгаа,Гран при шагналыг – Бум-Эрдэнийн Баярцэнгэл,Ноён хутагт Данзанравжаа” уран бүтээлийн уралдааны нэрэмжит шагналаар: Буяннэмэхийн Түвшинтөр, Ганхуягийн Мөнхзаяа нар шалгарлаа.

Нэрт соён гэгээрүүлэгч, говийн V ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан “Хос морьтой сайхан хос”, “Жороо морь” тэмцээнүүдийг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл, урлагийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар хамтран зохион байгууллаа. Хос морьтой сайхан хос тэмцээнд 5 сумын 6 хос, Жороо морь тэмцээнд 6 сумын 6 иргэн оролцож, шүүгчээр Худалдаа хөгжлийн банкны захирал Д.Буянбат, Музей сургалт судалгааны төвийн чихмэлч Г.Гантулга, Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Д.Отгонбаатар нар ажилласан.

❖ **“Жороо морь” тэмцээнд:**

Тэргүүн байр - Айраг сумаас оролцогч Батчимэгийн Батравжих  
Дэд байр – Сайхандулаан сумаас оролцогч Мараахайн Чинзоригт  
Гутгаар байр – Замын-Үүд сумаас оролцогч Дашням

❖ **“Хос морьтой сайхан хос” тэмцээнд:**

Тэргүүн байр – Даланжаргалан сумаас оролцогч Төмөрчулууны Батгэрэл,  
Цэмбэлдоржийн Мөнхзаяа /Хар морьтой/

Дэд байр – Эрдэнэ сумаас оролцогч Өвгөний Отгонбаяр, Даваагийн Оюунчимэг  
/Цоохор морьтой/

Гутгаар байр – Хөвсгөл сумаас оролцогч Гүнгэрэгийн Мөнхбат, Лоохорын Намуунбайгаль /Хүрэн халзан морьтой/

Шагналт 1,2,3-р байрыг тус бүр шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар /500.000, 400.000, 300.000 төгрөг/ шагналаа.

## **ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ТАЙЛАН:**

- “Нүүдэлчин Монгол-2023” наадмын баг бүрэлдэхүүн хуралдлаа
- Ноён хутагтын өв: Өнгөрсөн, одоо, ирээдүй сэдэвт Олон Улсын эрдэм шинжилгээний VI хурлын тайланг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
- Монгол Улсын төрийн шагналт, ардын жүжигчин, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит “Өсвөрийн бүжигчдийн улсын XVI наадам”-ын тайланг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн
- “Ноён хутагт Данзанравжаа” гар зураг, уран баримлын үзэсгэлэнгийн баннер хэвлүүлсэн.
- “Ноён хутагт Данзанравжаа” гар зураг, уран баримлын үзэсгэлэнгийн постер бэлтгэсэн.
- “Т интертаймент”-тай сумдын соёлын төвийн эрхлэгч нар болон Соёл урлагийн газрын хамт олон онлайн хурал зохион байгуулсан
- “Enaadam.mn” сайтад Говийн V Ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр наадмын мэдээллийг байршуулсан.
- Говийн V Ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр наадмын соёлын хөтөлбөр бэлтгэсэн.

## **МУЗЕЙ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ**

### ***Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:***

“Музейн үзүүлэгийн танхимаар 118 том хүн, 228 хүүхэд, нийт 346 хүнд үйлчилгээ үзүүлсэн.

Нээлттэй Дорноговь, Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан “НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖАА” уран бүтээлийн уралдааныг зохион байгууллаа.

“НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖАА” уран бүтээлийн уралдаанд 28 уран бүтээлчийн 58 бүтээл ирснээс 23 бүтээлийг дэлгэн үзэсгэлэн гаргасан. Уран бүтээлийн үзэсгэлэнд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын харьяат Урлагийн гавьяат зүтгэлтэн, Ардын зураач Л.Гаваагийн хүү Алтангадас одонт, Монголын урчуудын эвлэлийн гишүүн зураач Г.Төмөр, Монгол Улсын Ардын зураач Ц.Байды зэрэг уран бүтээлчид уран бүтээлээрээ оролцож, нээлтийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн.

“НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖАА” УРАН БҮТЭЭЛИЙН УРАЛДААНД:

Уран зураг төрөлд- Гаваагийн Төмөр

Уран баримал төрөлд- Насанбуянгийн Золжаргал

Зураасан зураг төрөлд- Д.Гунгаа

Гран при шагналыг – Бум-Эрдэнийн Баярцэнгэл

“Ноён хутагт Данзанравжаа” уран бүтээлийн уралдааны нэрэмжит шагналаар: Буяннэмэхийн Түвшинтөр, Ганхуягийн Мөнхзаяа нар тодорлоо.

#### **Цаг үеийн ажлын тайлан**

- Музейн үзэсгэлэнгийн танхимын засвар, тохижилтын ажлыг хийв.
- “Нүүдэлчин” фестивалд оролцох оролцогчдын нэрсийг хамтарсан хурлаар хэлэлцэв.

### **САРАН ХӨХӨӨ ТЕАТР**

#### ***Зорилтот арга хэмжээний хүрээнд:***

7 дугаар сарын байдлаар тус театр нь 6 төрлийн үйл ажиллагааг хамтран болон бие даан зохион байгуулж, 10,000 гаруй үзэгчдэд хүргэсэн.

#### ***Цаг үеийн ажлын тайлан:***

- Хойд 3-н замд зохион байгуулсан “Хун шувууны” шүтээний нээлтэд Морин хуурч Д.Мижиддорж, Уртын дуучин Ч.Дорж нар урлаг соёлоор үйлчилсэн.
- Байгууллагын өнгө үзэмжийг сэргээж гадна тохижилтын ажил болон гадна хашаа, гражийг будах ажлыг зохион байгуулан ажиллалаа
- Саран Хөхөө театрт шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах ажлын техникийн судалгааг Аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэв.
- Говийн V ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жил, Ардын хувьсгалын 102 жил, Дорноговь аймаг байгуулагдсан 92 жил, Сайншанд сум байгуулагдсан 62 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлж, хүндэтгэлийн тоглолт, оройн цэнгүүн, шагнал гардуулах ёслол, нээлтийн үйл ажиллагаа, хаалтын үйл ажиллагааг зохион байгуулж, 5000 гаруй наадамчин олонд соёл, урлагаар дамжуулан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа.

#### **ТӨВ НОМЫН САН**

#### ***Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:***

07 сарын байдлаар уншигч-6, ирэгсэд-90, Танхимаар ном олголт-165, Гэрээр ном олголт-77, Зөөврөөр /Хүүхдийн уншлагын танхим/ ном олголт-44, “Аз жаргалын өрөө”-нд 36 хүүхэд үйлчлүүлээ.

#### ***Цаг үеийн ажлын тайлан:***

Соёлын яамнаас орон нутгийн ажилтнуудад зохион байгуулах коха программын сургалтанд онлайнаар 5 албан хаагч хамрагдсан.

#### **Америкийн соёл мэдээллийн төвийн 6-р сарын тайлан**

Үйлчлүүлэгчдийн тоо	54
Зохион байгуулагдсан хөтөлбөрүүд	7

Хөтөлбөт оролцсон иргэдийн тоо	34
Уншсан номын тоо	11

Америкийн Соёл Мэдээллийн төв нь 2023 оны 7 дугаар сард оффисын засвар үйлчилгээний ажилтай холбоотойгоор хөтөлбөр болон үйл ажиллагааны хувьд идэвхгүй байж өнгөрөв. Засварын ажлын үеэр оффист төвийн халаалт оруулсан бөгөөд бүх талбайг ахин шинээр будаж янзалсан. Энэхүү засвар 7-р сарын 1-ны өдрөөс 7-р сарын 20-ны хооронд бүрэн дууссан. 7-р сарын 20-ноос эхлэн АСМТ-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн.

### **Let's Sing / Хамтдаа дуулцгаая!**

Энэхүү хөтөлбөр нь англи хэл дээр хамтдаа дуу болон хөгжим сурч тухайн дууны утгыг орчуулан хамтдаа ярилцдаг хөтөлбөр юм. Энэ сард 1 удаа зохиогдож 6 хүүхэд оролцлоо.

### **Spelling Bee**

Манай төвд тогтмол явагддаг энэ хөтөлбөр нь англи үгсийг зөв дуудах, зөв бичиж уншихад сургах зорилготой. Бид энэ хөтөлбөрөөр үгсийг чанга уншин үсэглүүлж хооронд нь уралдуулсанаар илүү сонирхолтойгоор хүүхдэд ойлгуулахыг зорьдог. Мөн адил 1 удаа явагдаж 4 оролцогчтой байлаа.

### **Speaking club**

Долоо хоног бүрийн Пүрэв гарагт явагддаг тус хөтөлбөр нь хоорондоо англи хэл дээр ямар нэг сэдвийн тухай ярилцдаг хөтөлбөр юм. Хүүхдийн ярих чадварыг хөгжүүлж, англи хэлээр ярих сандралыг арилгах зорилготой. Энэ удаагийн хөтөлбөрт 5 хүүхэд оролцож амжилттай болж өнгөрсөн.



## **Киноны цаг**

Бямба гарагт явагддаг тус хөтөлбөрт 7 хүний ирцтэй байсан. Энэ хөтөлбөрийн үеэр бид англи хэл дээрх кино болон хүүхэлдэйн кинонуудыг үзэн дүгнэлт хийж сонсох болон ойлгох чадвараа хөгжүүлдэг.

## **ABC English**

Сурагч багачуудын зуны амралт эхэлсэнтэй холбоотой 7 хоног бүрийн лхагва, пүрэв, баасан гарагуудад тус хөтөлбөрийг явуулдаг. Энэ сард 3 удаа явагдаж, 12 хүүхэд оролсон байна. Англи хэлийг суурьгүй анхан шатнаас системчлэн зааж байгаа онцлогтой.

## **ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС**

### **Санхүү, төрийн сангийн чиглэлээр:**

#### ***Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:***

- 2023 оны 08 дугаар сарын орлогын төлөвлөгөө 55.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс орон нутгийн төсөвт 35.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.
- Шилэн дансны хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад сар бүрийн 8-ны дотор төсөв хөрөнгөтэй холбоотой 50 захирамж хугацаандаа байршуулсан.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтад 5.2 тэрбум, Замын сангийн хөрөнгө оруулалтад 256.8 сая, орон нутгийн байгууллагад 2.2 тэрбум төгрөг, төрийн өмчийн байгууллагуудын тогтмол зардалд 144 сая төгрөгийн санхүүжилт олгож, улсад 500,0 сая төгрөг төвлөрүүлсэн.
- Орон нутгийн 2023 оны төсвийн тодотголыг эцэслэн боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.
- Сумдын ИТХ-аар батлагдсан 2023 оны төсвийн тодотголыг хүлээн авч нэгтгэн аймгийн 2023 оны тодотгосон төсвийг, аймаг сумын төсөв баталсан тогтоолын хамт Сангийн яаманд хүргүүлсэн.
- Аймгийн 2023 оны орон нутгийн тодотгосон төсвийн сар улирлын хуваарийг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулсан.
- Тодотгосон төсвийн сарын хуваарийг төсвийн төлөвлөлтийн фискал программд шивж, төсвийн баазыг Сангийн яаманд хүргүүлэн, ЗГУМС-д татуулж сум, төсвийн байгууллагуудыг гүйлгээ хийх боломжоор хангасан.
- Нэмэлт санхүүжилтийн 48 байгууллагын хүсэлтийг үндэслэн 356 сая төгрөгийн хүсэлтийг үндэслэн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2023 оны 07 сарын 1-31-ний

хооронд нийт 1466 гүйлгээний 16927.5 сая төгрөгийн төлбөр тооцоог Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд бүртгэснийг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн шаардлагатай тохиолдолд анхан шатны баримтын бүрдлийг тулган баталгаажуулж ажилласан.

#### **Статистикийн хэлтэс:**

##### **Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны 6 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудас болон фейсбүүк хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар, тархаасан.
- Гол нэр төрлийн 12 бараа бүтээгдэхүүний үнэ болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн Даваа гаригт Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, программд шивэн, хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд дамжуулав.
- Сар бүрийн 21-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд дамжуулсан. Мөн Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдын мэргэжилтнүүд 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг программд шивж Үндэсний статистикийн хороонд дамжуулав.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АУ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-ЗГ-1, А-ЗБ-1/, худалдааны салбарын сарын /ХУ-1/ мэдээ, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИУ/, худалдааны салбарын /ХСҮ/ сум, авто усан замын тээврийн улирлын мэдээ /Т-1/ Мэдээлэл харилцаа холбооны улирлын /МХХ-3, МХХ-4, МХХ-6, МХХ-7/ мэдээг, хөдөө аж ахуйн /ХАА-2, ХАА-3, ХАА-10/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж, программд шивж дамжуулсан. Төрийн бус байгууллагын улирлын мэдээ/ТББ/, Мал эмнэлгийн улирлын /МЭ-1/, барилга байгууламж, объектын улирлын мэдээ /ББО/, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ /АЖ/-г графикт хугацаанд нь дамжуулан ажилласан.

#### **Татварын хэлтэс:**

##### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Улс ба орон нутгийн төсөвт **9434,3** сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 278 татварын тайлан, 358 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан. 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 125, өрөөгөөр 98 татвар

төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөөг өгсөн.

- Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ орон нутагт хэрэгжиж 1800-1288-д 882 дуудлага ирж зөвлөгөө мэдээллийг өгч, ирүүлсэн 47 гомдлыг хуваарилан 32 -г шийдвэрлэж баталгаажуулсан.
- Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүссэн 13 хуулийн этгээдийн мэдээллийг ТУНС-д бүртгэж, НӨАТ суутган төлөгчөөр 6 хуулийн этгээдийг бүртгэсэн байна.
- Газар шилжилт хийж байгаатай холбогдуулан газрын төлбөрөө төлж барагдуулсанд хяналт тавих 25 татвар төлөгч газар эзэмших эрх шилжүүлж 1,462,680 төгрөгийн төлбөрөө бүрэн төлж барагдуулсан.

### **Орон нутгийн өмчийн газар :**

#### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц**

- Дорноговь аймгийн 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 12/05 дугаар тогтоолыг үндэслэн 18 төсөл арга хэмжээг сумд руу эрх шилжүүлж, 20 төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны нарийн бичиг болон гишүүдийг томилж, үнэлгээний хорооны захирамжийг боловсруулсан.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах төсөл арга хэмжээний тендерийг зарласан. Үүнд:
  1. Саранхөхөө театрын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил
  2. Ахмадын сувиллын үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах ажил
  3. Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв гүйцэтгэх зардал
  4. Цагдаагийн газраас Дэнжийн пост хүртэл авто зам дагуу явган хүний зам, дугуйн зам барих ажил /1.5 км/
  5. Аймгийн Цагдаагийн газарт туулах чадвар сайтай жийп автомашин худалдан авах
  6. Алтанширээ сум, Дэлгэрэх сум, Иххэт сум, Хөвсгөл сум, Эрдэнэ сум, Замын-Үүд сумын Цагдаагийн газар,туулах чадвар сайтай жийп автомашин худалдан авах ажил
  7. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд монгол гэр худалдан авах ажил
  8. Багийн Засаг дарга нарын албан хэрэгцээнд мотоцикл худалдан авах
  9. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зөөврийн компьютер худалдан авах ажлуудын техникийн тодорхойлолтын дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулан тендерийг зарласан.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээний тендерийн хариу мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулах эрх олгогдсон. Үүнд:
  1. Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1-р байрны их засварын ажил
  2. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, урлагийн ордонд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах багц-1 ажил
  3. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, урлагийн ордонд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах багц-2
  4. Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих ажлуудыг тус тус нарийвчилсан үнэлгээг хийж, гэрээ байгуулах эрх олгогдсон.
- Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн Сайншанд сумын хүүхдийн парк, 8-р багийн дугуйн зам, Нийтийн орон сууцны сантехникийн ажил, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажил, Шинэ хөдөө төсөл трактор, дагалдах тоног төхөөрөмжийг байнгын ашиглалтад хүлээж авах комисст ажилласан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй худаг Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд 2, Айраг суманд 2, Иххэт суманд 1-ийг тус тус шинээр гаргаж тухайн сумдын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгүүлсэн.

#### **Санхүүгийн хяналт, аудитын алба:**

##### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Аймгийн Засаг даргаар батлуулсан 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 01 тоот удирдамжаар Аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газрын 2021-2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, шалгалтаар нийт 70364,5 мянган төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, орон нутгийн төсвийн орлогын дансанд нөхөн төлүүлэхээр 65929,5 мянган төгрөгийн, эргүүлж олгуулахаар 4435,1 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн 5 акт тогтоож, шалгалтын дүнгийн хурлыг албан хаагчдын дунд нээлттэй, ил тод хийж, шалгалтын нэгдсэн акт болон улсын ахлах байцаагчийн нэгбүрчилсэн акт, цаашид авах арга хэмжээний саналыг 2023 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 113 тоот албан бичгээр Боловсрол шинжлэх ухааны газарт, 115 тоот албан бичгээр Сумдын Засаг дарга нарт, 114 тоот албан бичгээр сумдын Сургууль цэцэрлэгийн эрхлэгч нарт, 116 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад, 117 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүллээ.
- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын 01 тоот нэгдсэн удирдамж, Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 14 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 8 дугаар

Цэцэрлэгийн 2021, 2022 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, шалгалтын дүнгийн хурлыг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хийсэн ба шалгалтын нэгдсэн акт бичигдэж байна.

- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын 01 тоот нэгдсэн удирдамж, Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 15 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 4 дүгээр Цэцэрлэгийн 2021, 2022 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, шалгалтын дүнгийн хурлыг хийхээр хүлээгдэж байна.
- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын 01 тоот нэгдсэн удирдамж, Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 02 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 1 дүгээр Цэцэрлэгийн 2021, 2022 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын нэгдсэн актыг тус байгууллагад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 121 тоот албан бичгээр хүргүүлээ.
- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын 01 тоот нэгдсэн удирдамж, Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 08 тоот удирдамжийн дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудыг хөгжлийн газрын 2021, 2022 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт үргэлжлэн хийгдэж байна.
- 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хийж, Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдэлийн удирдлагын газарт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 122 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Тайланд сард 1053,2 мянган төгрөгийн актын төлбөрийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

#### **ТАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС:**

- Тендерийн худалдан авалтын үйл явцын талаар ГХБХБГ, ОНӨГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хуралдсан. 2023 онд батлагдсан нийт 99 төсөл арга хэмжээний нийт гүйцэтгэл 98,9 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Тендерт шалгарсан гэрээ байгуулах эрх бүхий 21 компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Мөн зураг төсөл боловсруулах 15 төсөл арга хэмжээний гэрээ байгуулсан.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 47 төсөл арга хэмжээнд 15,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээсэн.
- ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн 40 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.
- Өвс тэжээлийн тооцоо хийж сумдын Засаг дарга нарт төлбөр барагдуулах чиглэл өгсөн.

- Хэлтсийн албан хаагчид бүгд хувийн хэргээ бүрдүүлж өгсөн.
- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүртгэлийн жагсаалтыг бүрэн гүйцэт болгон хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.
- Аймгийн нөөцийн агуулахад хадгалагдаж байсан болон шинээр татан авчирсан өвс тэжээлээс сумдуудын авсан өр төлбөрийн тооцоог гаргахад 90,517,000 төгрөг болсон.
- Аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний 2023 оны нэгдсэн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- Газартай холбоотой эрх шилжүүлэх, өмчлөх зэрэг 6 захирамжийг гаргаж ГХБХБГ-т хүргүүлсэн.
- Аймгийн хэмжээнд 2023 оны 07 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Иххэт суманд зохион байгуулах хурдан морины “Хойд бүс”-ийн уралдааны товыг аймгийн Засаг даргын захирамж батлуулсан.
- Аймгийн ИТХ-аар баталсан Дорноговь аймгийн аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөөг сурталчлан таниулах, зорилтот сумдад хоршооллын системийг дэмжих хөтөлбөр болон системийн загвар 5 төслийг хүлээлгэх, гардуулж өгөх ажлаар зарим сумдад томилолтоор ажилласан.
- Хэлтэст тухайн сард нийт 112 албан бичиг ирж, хариутай 45, бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, бусад 55 албан бичиг нь мэдээлэлд авах болон цаашид авч хэрэгжүүлэх тухай байсан.
- Хамарын хийд”, “Ханбаян зүрх” уул орчимд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нэр бүхий 8 иргэнээс ирүүлсэн өргөдлийг судлан шийдвэрлэх чиглэлийг Сайншанд сумын Засаг даргад чиглэл болгосон.
- Аймгийн Засаг даргын захирамжаар худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт холбогдох стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэг, удирдамжийг баталсан.

## **ЗУРГАА: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

### **Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр**

Агентлаг, сумдын 2022 оны үйл ажиллагааны болон аймгийн бодлогын баримт бичгүүдийг бүрэн архивлаж дуусгасан. Үүнд:

1. Агентлагийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайлан – 1 баримт
2. Сумдын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэсэн зөвлөмж – 1 баримт
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн сургалт, зөвлөгөөний сургалтын материал – 1 баримт
4. Сумдын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн тайлан – 1 баримт
5. Агентлагуудын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн тайлан – 1 баримт

6. Сумдын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайлан – 1 баримт зэрэг болно.

### **Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтөлж, удирдлагуудад танилцуулах**

Монгол Улсын Засгийн Газрын 2023 06 дугаар сарын 07-ны өдрийн 221 дүгээр “Зарим аймаг байгуулагдсаны ойг тэмдэглэх болон баяр наадмын хугацааг тогтоох” тухай тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 212 дугаар “Ой тэмдэглэх тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 213 дугаар тогтоол “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 23 дугаар “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тэмдэглэл, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 203 дугаар “Алсын хараа-2025 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, онцлох ажлуудын хэрэгжилтийн явцын талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 203 дугаар “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр “Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав” тэмдэглэл, 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр “XVIII.3.Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав тэмдэглэл зэргийг хяналтад авч, удирдлагуудад танилцуулан, бүртгэлжүүлсэн.

### **Бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 305 заалт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 277 заалтын хэрэгжилтийг тус бүрт нь үнэлж, дундаж үнэлгээ, үр дүнтэй ажлууд болон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг ангилан хэлтсийн ахлах мэргэжилтнээр хянуулсан.

Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөний 22 заалтаас 11 заалтын хэрэгжилтийг хянан цахим санд байршуулсан.

### **Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс хасуулах заалтын санал авч нийт 10 гаруй агентлаг, сумдын 80 орчим заалтыг хяналтаас хассан.

2023 оны эхний хагас жилийн тайлантай холбоотойгоор “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс 8 агентлаг, 5 сумын 60 орчим заалтыг чиг үүрэгт нь хамаарахгүй гэсэн үндэслэлээр тайлагналтаас нь хассан.